



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/02

Дэлгэрмөрөн

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалаар батлагдсан “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам”-ын 3.1, 3.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн А/737 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Агаарын бохирдлын эс үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийг 2022 оны 01 дүгээр сарын 03-ний өдрөөс 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тооллогод хамруулж, бүртгэл хяналтын нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Отгонбаяр (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүдэд: Э.Даваасүрэн (Байгаль хамгаалагч)

Б.Амартүвшин (Цаг уурын техникч)

Ч.Хүчитбаатар (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Ю.Батмөнх (Хөхбүрд 1 дүгээр багийн Засаг дарга)

С.Төмөрбаатар (Соноор 2 дугаар багийн Засаг дарга)

П.Түвшинтөгс (Норовлин 3 дугаар багийн Засаг дарга)

Б.Батшагай (Цорж 4 дүгээр багийн Засаг дарга)

С.Очирбат (Дэлгэрмөрөн 5 дугаар багийн Засаг дарга)

3. Агаарын бохирдлын суурин эх үүсвэрийн бүртгэл тооллого явуулан дүн мэдээг 2022 оны 01 дүгээр сарын 15-ний өдрийн дотор багтааж холбогдох байгууллагад хүргэж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

Zahiramj -2022 on

642101177

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Баярсайхан)-д даалгасугай.

ДАРГА *Сумъяабазар* С.СУМЪЯАБАЗАР

